

“Кёнгүг Тэжон Жүхэ”¹-д тэмдэглэсэн монгол хэлний бичгүүд

С.Батхишиг
Дангүг Их сургууль

ХТ 900-аад он буюу *Солонгосын Гурван улс* (Гурё - 高句麗, Шилла - 新羅, Пэгжэ - 百濟)-ын Гурёгийн үед хөрш зэргэлдээ улс орнуудтай харилцах, тэдгээрийн хэл заншлыг судлах тусгай бичгийн түшмэл, хэлмэрчдийг бэлтгэх “*Орчуулгын товчоон* (通文館)” [С.Б.] байгуулагдсан гэж “*Гурван улсын түүхэн тэмдэглэл* (三國史記)”-д дурджээ. Дараа нь Чусон (朝鮮)²-ы үед нэрий нь “*Түүхийн хүрээлэн* (司譯院)” [С.Б.] болгож, монгол, хятад, япон, манж хэлний хэлмэрч бэлтгэх болсон байна.

XVIII зууны сүүл үед Чусоны “*Түүхийн хүрээлэн*”-гээс хэвлэн гаргасан *Мун-о Ну-гол-дэ* (蒙語老乞大), *Чоб-хэ Мун-о* (捷解蒙語), *Мун-о Юү-хэ* (蒙語類解) зэрэг монгол хэлний ном бидний үед уламжлан ирсэн бөгөөд Монгол судлалд “*Монгол хэлний гурван ном*” (The Three Books for the Study of Mongolian <In Korea>) хэмээн алдаршжээ.

Эл гурван номоос урьд, мөн монгол хэлээр зохиосон 16 номыг Солонгост гаргаж байсан тухай мэдээ “*Кёнгүг Тэжон Жүхэ*” (經國大典註解) хэмээх сурвалжид үлдсэн байна³. Тус сурвалжид номын нэрс болон нэрийн тайлбарт холбогдох тэмдэглэл байх агаад энэ талаар солонгос, англи хэлээр цөөнгүй судлагаа хэвлэгдэн гарсныг *Холбогдох бүтээл хэсгээс* үзнэ үү. Монголын эрдэмтдээс Б.Сумьяабаатар “*Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал*” (1975) хэмээх бүтээлдээ дурдсан байна. Бид энэ тэмдэглэлд тэрхүү 16 номын тухай товч танилцуулья.

1. Нэр нь уламжилсан 16 зохиолын нэг бол даруй Монгол судлалын 3 номын нэг болох *Ну-гол-дэ* (老乞大) юм. *Мун-о Ну-гол-дэ* (蒙語老乞大)-г 1741 онд модон бараар хэвлэсэн ба 1776 болон 1790 онд дахин засаж хэвлэжээ. “*Кёнгүг Тэжон Жүхэ*” (經國大典註解)-д тэмдэглэсэн *Ну-гол-дэ* (老乞大) нь 1741 онд модон бараар хэвлэхээс өмнө байсан гэх бөгөөд дайны үед алдагдан XVIII зууны сүүл үед Чусоны “*Түүхийн хүрээлэн*”-гээс дахин хэвлэн гаргасан гэж таамагладаг байна.

¹ 經國大典註解 - Чусоны үед хэвлэгдэн гарсан хууль цаазын бичгийн тайлбар

² 1392-1910 он.

³ Сун Ги Жүн, “Кёнгүг тэжон”-д уламжилсан Монгол судлалын сурвалжуудын нэрсийн тухайд(1), Journal of Korean Linguistics 16, 1985, pp.151-175. И Сөн Гюү, “Монгол судлалын гурван ном”-ын монгол хэлэнд холбогдох суурь судалгаа, Mongolian Studies 2, The Korean Association for Mongol Studies, 1994, pp.21-47.

Уламжлан үлдсэн *Мун-о Ну-гол-дэ* (蒙語老乞大) 1790 оны зассан эх бөгөөд зохиолын эхийг монгол бичгээр бичиж, солонгос үсгээр дуудлагыг галиглахдаа тухайн үеийн ярианы хэлээр тэмдэглэсэн нь авианзүйн сонирхолтой баримтуудыг тусгасан байна. Жишээ нь,

монгол бичиг. üge-yi
хангыл галиг. üge-gi

монгол бичиг. tngri
хангыл галиг. tengeri

монгол бичиг. kümün
хангыл галиг. kün⁴

Мөн монгол бичигт ижил дүрсээр тэмдэглэдэг d(ㄷ), t(ㅌ), ö(ㅍ), ü(ㅍ) зэргийг солонгос үсгээр ялган галигласан онцлогтой. “*Мун-о Ну-гол-дэ*” (蒙語老乞大) нь хэлзүйн хувьд 17-18-р зууны ярианы хэлийг тэмдэглэсэн сонирхолтой дурсгал болохоос гадна “...бүтэц зарчмын хувьд МНТ-ны бүтэц зохиомжтой тохирч байгаа ба дундад зуунаа Төв Азийн олон орноо нийтлэг хэрэглэгдэж бараг уламжлал болчихсон гадаад хэлний сурах бичгийн тогтсон зарчим гэж үзэх боломжтой”⁵ гэж Монголын эрдэмтэн Ц.Шагдарсүрэн дүгнэжээ.

Проф. Ц.Шагдарсүрэн МНТ болоод “*Мун-о Ну-гол-дэ*” (蒙語老乞大)-гийн зохиомж бүтэц, зохиогдох болсон шалтгааныг үндэслэн “*Монголын нууц товчоон*”-ы уг эхийн талаар эргэцүүлэх нь” өгүүлэлдээ “*Дундад зуунаа, Хятадаас гадна хятад хэл бичигийн хүрээнд гүнээ хамрагдсан Ази дахины олон оронд гадаад хэлний сурах бичиг нь ЛЦД⁶ маягийн байсан гэж үзэх үндэслэл гарч байна*” гэжээ.

Энэ бүхнээс үзэхэд Солонгосын Чусоны үед гарсан “*Кёнгүг Тэжон Жүхэ*” (經國大典註解) хэмээх номд тэмдэглэсэн 16 ном бүгд сурах бичгийн журмаар зохиогдсоноос гадна гадаад хэлийг сурахад тухайн орныхоо түүх, амьдрал, үлгэр домог, сурч буй бичиг үсгийнхээ талаар давхар мэдлэгтэй болох зорилготой байсан болов уу. 16 номын дотор Монголын түүх, соёл, амьдрал, үлгэр домогт холбогдолтой нэрс гарахаас гадна нангиад хэлнээс орчуулсан зохиолууд ч байсан бололтой. Дурдсан *Мун-о Ну-гол-дэ* (蒙語老乞大) ч нангиад юм уу, харь хэлээрхи зохиолыг монголчлоод солонгос хэл сурахад дөхөмтэй болгож солонгос үсгийн галиг, орчуулгыг хадсан гэж болно. *Мун-о Ну-гол-дэ* (蒙語老乞大)-д Чусон газрын хүн Бээжинд очиж морь, зотон худалдахаар явах замдаа хятад нөхөртэй таарч нөхөрлөөд хятад хэл сурсан хийгээд явж буй зорилго барааны үнэ, наймаа хийж буй явц зэргийг харилцан яриагаар үзүүлсэн байдаг. Чусоны үед гарсан манж хэлний ну-гол-дэ ч агуулга, зохиомжийн хувьд адил юм.

Ну-гол-дэ (蒙語老乞大) -д өгүүлж буй нэгэн сонирхолтой зүйл бол Чусоны хүн хятад хэлийг ямар зорилгоор хаана, яаж сурсан бэ гэдгийг тодорхой гаргасан байна.

- *či čookiyan kümün. kitad üge[=kele]-yi yakiji[=yayakiju] sayiqan čidamui[=yarimui].*
- *bi kitad kümün-eče bičig suruysan-u tulada kitad üge-yi baqan čidan_a.*

- *či yamar bičig-i surun_a.*
- *lüwen üüi mengzi šausqu-yi suruba.*

- *či edür büri yaγun-i kičiyegemüi[=kičiyemüi].*
- *bi edür büri erte bosču surγayuli-du ečiged bičig surču daγusuyan qoyin_a gerte[=ger-tegen] qariju buday_a[=xool] ideged jiči[=bac] surγayuli-du ečijü bičig-ün üsüg bičiged baysi-yin emün_e tayilburilaqu bišwü[=bisi-üü].*

- *či čooqyan[=čookiyan] kün[=kümün] kitad bičig-i surču yaukin_a[=yaγu_kin_e].*

⁴ *Mongolian Lao Kida*. Source Materials for Korean Studies No. 3, Research Institute for Humanities Sogang University, Seoul, 1983.

⁵ Ц. Шагдарсүрэн, “*Монголын нууц товчоон*”-ы уг эхийн талаар эргэцүүлэх нь, *Acta Mongolica*, National University of Mongolia, 2006, Volume 6(267), 155-172.

⁶ *Ну-гол-дэ*(老乞大)-ийн ханзны хятад дуудлага болох Lao Kida буюу Лао цидан-гийн товчилсон.

- *edüge qayan beyisw ... yirtincü-dü cöm kitad üge bišwü. biden-ü ene cöokiyan üge yaŋca cöokiyan yajar-un tedii.*⁷

Монгол хэлийг сурахад ч мөн дээр иш татсаны адил монгол хэлний сургуульд явж монгол хэлний сурах бичгүүдийг уншдаг байсан нь тодорхой юм. Номын нэрсээс үзэхэд 13-14-р зууны үеийн Монголын түүх, соёлд тулгуурласан сурах бичгүүд байсан гэж үзэж болох байна.

2. Ван хаган (wang qayan – 王可杆)

“Кёнгүг тэжон жүхэ”-д тэмдэглэснийг үндэс болгон Чингис хааны эцэг Есүхэйн анд Монголын Хэрэйд аймгийн Ван хааны тухай өгүүлсэн ном байсан гэж эрдэмтэд үздэг.

3. Хулан хатун (yulan qatun ~ qulan qatun – 高難加屯)

“Кёнгүг тэжон жүхэ”-д “хатны нэр” хэмээн тайлбарласан байдаг. Энэ үгийг И Ги Мүнх(1967), Б.Сумъяабаатар(1975) нар салангид үг болгон тайлбарласан байна. Мөн монгол хэлний “гунан” гэдэг үгтэй холбосон нь буй. Гэвч энэ нь солонгос хэлний ㄱ гийгүүлэгчээр монгол хэлний ү гийгүүлэгчийг тэмдэглэдэг бөгөөд үгийн эхэнд орсон солонгос хэлний ㄱ гийгүүлэгч нь ү бус q/k-д ойрхон дуудагддагтай холбоотой болов уу. Үүнийг баталж дундад үеийн солонгос хэлэнд орсон монгол үгийн үгийн эхний q(ᄑ), k(ᄑ) гийгүүлэгчийг хангыл үсгийн ㄱ(γ/g)-ээр тэмдэглэсэн зүйл байдаг. Жишээ нь,

Монгол бичгийн хэл. **qongyog mori**

Солонгос үсгээр. *yongyog mori*

Монгол бичгийн хэл. **qara**

Солонгос үсгээр. *qara*

Монгол бичгийн хэл. **kedüyin**

хангыл галиг. *gedüin*⁸

Түүнчлэн 難 ханзны солонгос дуудлага la –аар ч унших боломжтой. Иймд энэ номын нэрийг “Хулан хатан” гэж үзүүштэй санагдана.

4. Тогоон (tuŋu`an – 吐高安)

“Кёнгүг тэжон жүхэ”-д “хүний нэр” гэж тэмдэглэсэн байдаг байна. Дундад монгол хэлний авианзүйн онцлогийг тусгасан.

5. Баян Бат (pa`an padu - 伯顏波豆)

“Кёнгүг тэжон жүхэ”-д “жанжны нэр” гэж тэмдэглэсэн байдаг байна. Профессор И Ги Мүнх pa`an гэдгийг хүний нэр гэж үзээд padu гэдэг нь баатар гэсэн үг гэж нотлохыг зорьсон боловч нэгд, padu гэдэгт -ᄑ гийгүүлэгч тэмдэглэгдээгүй, хоёрт, монгол хэлний уртатгалыг тэмдэглэдэг дундад үеийн монгол хэлний хувилбар “-a`a”-г өмнөх pa`an гэсэн үгэнд тэмдэглэсэн мөртөө padu гэсэн үгэнд орхин тэмдэглэсэн байх боломжгүй болов уу. Юань улсын судар зэрэг монгол хэлийг нангиад үсгээр тэмдэглэсэн сурвалжуудад баян гэдэг үгийг дээрх номын нэртэй адилаар pa`an гэж галигладаг гэж Б.Сумъяабаатар тэмдэглэжээ.

6. Занги (janggi – 章記)

“Кёнгүг тэжон жүхэ”-д “Юань гүрний хаадын захидлын тухай” гэж тэмдэглэсэн байдаг байна. Монгол хэлний занги гэдэг үг нь хэд хэдэн утгатай.

занги *хошууны доторхи сумыг захирагч*

занги *сураг, чимээ*

⁷ *Mongolian Lao Kida, Source Materials for Korean Studies No. 3, Research Institute for Humanities Sogan University, Seoul, 1983.*

⁸ *Mongolian Lao Kida, Source Materials for Korean Studies No. 3, Research Institute for Humanities Sogan University, Seoul, 1983.*

занги шаазгайнаас багахан биетэй, салаа сүүлтэй шувуу
занги зангидсан уяа⁹
“Кёнгүг тэжсон жүхэ”-д “Юань гүрний хаадын захидлийн тухай бичсэн” гэснийг баривал монгол хэлний сураг занги, сураг чимээ гэсэн утга бололтой.

7. Субаши (Supasi – 速八實)

“Кёнгүг тэжсон жүхэ”-д “Хүний нэр” гэж тэмдэглэсэн байдгийг баримтлан Сун Ги Жүн(1985) “Су баги”(Su baysi) гэж буулгасан бол Б.Сумъяабаатар(1975) “Согналсил буюу Субашид” гэж буулгаад “Субашидыг Юань улсын үед монгол уйгар үсэг хийгээд дөрвөлжин үсгийн аль алинаар нь хэвлэсэн, ерөнхийдөө дэлгэр тархсан ном байсан тул Субашид нь Солонгост монгол хэлний сурах болж байсан гэж хэлэхэд бүрэн үндэстэй” юм гэжээ.

Ханзны солонгос дуудлагаар үгийн эцэст тэмдэглэсэн гийгүүлэгчийг хятад үсгийн дуудлагаар уншдаггүй зүйл бий. Тэгвэл солонгос дуудлагаар suu pal sil гэж тэмдэглэсэн энэ үг **supasi** болно. “Хүний нэр” гэсэн “Кёнгүг тэжсон жүхэ” номын тайлбарыг баривал Су багш гэж уншиж болох ч baysi гэдэг үгийн “-ү-”-г яагаад тэмдэглээгүй вэ, Юань гүрний үед өргөн дэлгэр тархсан байсан “Субашид”-ыг нэрлэсэн гэвэл үгийн эцсийн “-da”-г яагаад тэмдэглээгүй вэ гэсэн асуудал гарч ирнэ.

8. Дөрвөлжин (debwöljin – 帖月眞)

Эрдэмтэд энэ номыг дөрвөлжин бичгийн сурах бичиг байсан гэж таамагладаг. Энэ үгийн эхний үеийг тэмдэглэсэн үсэг буюу 帖 нь “Монголын нууц товчоо”-нд **te-** гэсэн үеийг тэмдэглэхэд хэрэглэж байсан ба дундад зууны үеийн дуудлага нь **teb** байжээ.

9. Горира (gerila ~ gerel - 巨里羅)

“Кёнгүг тэжсон жүхэ”-д “Үнэгний нэр” гэж тэмдэглэсэн байдаг ба Юань улсын эрдэмтэн Загоду гэдэг хүн орчуулсан гэж дурджээ. Зарим эрдэмтэн эхний үеийг гё- гэж уншсан нь бий ч Чусоны үед гарсан *Mong-ö nogöl-tae* (蒙語老乞大)¹⁰ буюу бидэнд уламжлан үлдсэн монгол ярианы сурах бичигт монгол бичгийн хэлний “e”-г хангыл буюу солонгос үсгээр галиглахдаа ʻö(으)-гөөр тэмдэглэсэн байдаг. Үүнд үндэслэн Солонгос эрдэмтэн И Ги Мүнь солонгос хэлний ʻö(ё) эгшиг нь монгол хэлний ʻe-тэй тохирно гэжээ¹¹. Үгийн эцэст орсон 羅(ra)-гийн тухайд энэ үгээс гадна 10-д тайлбарласан haçi hüra - 何忒厚羅 хэмээх үгийн төгсгөлд бас давтагдсан байна. Дээрх мэт тайлбарлан уншвал *гэрэл* гэсэн үг байж болох ч үнэгний нэр байх боломжгүй ба харин *гавар* байх боломжтой байж болох юм. 8 дугаарт буй **Дөрвөлжин** (debwöljin – 帖月眞)-гийн эхний ханз буюу **teb**(帖)-ийн **b**, горира-ийн хоёрдугаар үеийн **r** хоёроос харвал энэ хоёр гийгүүлэгч сэлгэдэг байсан байж болох юм.

10. Ач үр (haçi hüra ~ açi üre - 何忒厚羅)

“Кёнгүг тэжсон жүхэ”-д “ачлал хариулах” гэсэн утгатай гэжээ.

МНТ зэрэг дундад үеийн монгол хэлний дурсгалуудад тэмдэглэгдсэн байдаг шүргэх h-тэй бичигдсэнээс үзвэл сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн зохиол байсан болов уу.

11. Күнз ~ Кунбүза (kunbüja – 孔夫子)

“Кёнгүг тэжсон жүхэ”-д “хөвгүүдийн сурах бичиг” гэж тэмдэглэсэн байдаг байна. Энэ нь Күнз /Конфузы/-ийн суртлын ном бололтой бөгөөд анхан бичиг сурах хөвгүүдэд үзүүлдэг номын нэг байсан байх аа.

⁹ Ш.Чоймаа нар, *Монгол хэлний хэлзүйн толь бичиг I*, Хөх хот, 2006, 370-371-р тал.

¹⁰ *Mongolian Lao Kida*, Source Materials for Korean Studies No. 3, Research Institute for Humanities Sogon University, Seoul, 1983.

¹¹ Lee Gi-Moon, *Study of Mongolian Lao Kida*, 1964, pp. 369-427.

12. Сүсөнсагам (守成事鑑)
13. Өсажам (御史箴)
14. Хуандутэхунь (皇都大訓)
15. Тэрүвоньги (待漏院記)
16. Чонгуаньчонюу (貞觀政要)

12-16 дугаарт бичигдсэн таван номыг нангиад хэлнээс Алинтөмөр, Хутулу, Төрмиш нар монголчилсон¹² тухай тэмдэглэл байхаас өөр холбогдох мэдээ үгүй байна.

Солонгосын эрдэмтэн И Сөн Гюү(1994, 28) “Юань гүрний үед монгол хэлээр орчуулсан олон зохиол Чусоны үед уг эхээрээ монгол судлалын сурвалж болж байсан бөгөөд тэдгээрийг анх монгол хэл рүү орчуулахдаа ямар үсгээр буулгасан байсан нь сонирхолтой юм” гэжээ.

Дээрх Монгол судлалын номуудыг үндэс болгон Солонгосын эрдэмтэн Чон Жэ Мүнх(정제문) “Монгол хэлний судлал нь манай улсад 600-аад жилийн түүхтэй хөгжсөөр иржээ”¹³ гэж тэмдэглэсэн байна.

ХОЛБОГДОХ БҮТЭЭЛ

СОЛОНГОС ХЭЛЭЭР

- Chung Kwang, Se-Young Yoon, & Ki Joong Song(1992), *Printing Blocks of the Sayogwon of Chosôn Dynasty*, Journal of the Sungkok Academic & Cultural Foundation Vol. 23, Seoul, 2305-2387.
- Chung Kwang & Han Sang-kwon(1985), *Studies on the Historical Changes of Sayôg-wôn and its Textbooks*, Duksung Women's College Journal Vol. 14, Seoul: Duksung Women's College, 169-234.
- Chung Kwang & Yoon Se-Young(1998), *A Study on Printing Blocks of Foreign Languages Books of the Sayogwon of Chosôn Dynasty*, Seoul: Korea University Press.
- Kang Shin-hang (1978), *The Interpreters and Policies Regrading Interpreter System of the Yi-Dynasty*, Seoul: Tower press.
- Kim Bang-Han (1966), *On the materials in Mongolian preserved in Kyujang-gak*, The Paek-San Hakpo 1, Seoul: the Paek-San Society, 91-132.
- Kim Bang-Han(1967), *A Survey of the Mongolian Materials in Korea*, Journal of the Asia Academy in Korea 3, Seoul: Asia Academy in Korea, 125-146.
- Lee Ki-Moon(1964), *Studies on the Mongolian Lao Ki-da*, The Chin-Tan Society, National Museum of Korea, pp. 369-427.
- Lee Ki-Moon(1967), *Problems in the Study of Mongolian-Korean Materials*, The Chin-Tan Society, National Museum of Korea, 89-113.
- Lee Ki-Moon(1993), *A Reanalysis of Mongolian Words in the Koryôsa*, Journal of the National Academy of Sciences 32, The National Academy of Sciences Republic of Korea.
- Lee Seong-gyu(1994), *A Basic Study of the Mongol Language in Mong Hak Sam So*, Mongolian Studies 2, 21-47.
- Song Ki-Joong(1985), *On the Titles of Books for the Study of Foreign Languages Shown in the Kyôngguk Taejôn(I)*, Journal of Korean Linguistics 14, p. 115-148.
- Song Ki-Joong(1985), *On the Titles of Books for the Study of Foreign Languages Shown in the Kyôngguk Taejôn(II)*, Journal of Korean Linguistics 16, p. 151-175.

¹² Сун Ги Жүн, “Кёнгүг тэжсон”-д уламжилсан Монгол судлалын сурвалжуудын нэрсийн тухайд(I), Journal of Korean Linguistics 16, 1985, pp.127-147. И Сөн Гюү, “Монгол судлалын гурван ном”-ын монгол хэлэнд холбогдох суурь судалгаа, Mongolian Studies 2, The Korean Association for Mongol Studies, 1994, pp.27-47.

¹³ Чон Жэ-мүнх, Солонгос дахи монгол хэл судлалын түүх, (정제문, 「한국의 몽골어학 연구사」, 언어학연구사), Seoul, 1991, p.574-592.

- Song Ki-Joong(1988), *Mongolian Grammar Understood by the Koreans of the 18th Century*, Papers - of the 5th International Conference on Korean Studies, Seoul: The Academy of Korean Studies, 660-686.
- Song Ki-Joong(1993), *Books for the Studies of Mongolian*, Collection of Studies Published in Commemoration of the 60th Birthday of Prof. Pyong-Hi Ahn), Moonhak-kwa-Jisung-Sa, 271-296.
- Song Ki-Joong(1997), *The present situation and problems in the studies of books for foreign languages of the Chosôn Dynasty*, Korean Language and Literature 5, 119-191.

АНГЛИ ХЭЛЭЭР

- Lee Ki-moon(1963), *The Hunmin-jôngôm System*, Historical Studies on the Korean Writing System, The Korean Series, Vol. 18, Linguistics, Korean Research Center, Seoul. P.9.
- Lee Ki-moon(1981), *The Study of Foreign Languages in the Yi Dynasty(1392-1910)*, Journal of Social Sciences and Humanities 54, Seoul: the Korean Research Center, 1-45.
- Lee Ki-moon(1982), *The Study of Foreign Languages in the Yi Dynasty(1392-1910) Part Two-Books for the Study of Foreign Languages (1)-*, Journal of Social Sciences and Humanities 55, Seoul: Korean Research Center, 1-63.
- Lee Ki-moon(1982), *The Study of Foreign Languages in the Yi Dynasty (1392-1910) Part Three-Books for the Study of Foreign Languages(2)-*, Journal of Social Sciences and Humanities 56, Seoul: Korean Research Center, 1-45.
- Seong Baeg-In, *Mongolian language studies in Korea*, The Third International Symposium on Mongology, August 17-24, 1998. Inner Mongolia University, Hohhot, China.

МОНГОЛ ХЭЛЭЭР

- Сумьябаатар Б (1975), *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар.
- Шагдарсүрэн Ц (2001), *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Улаанбаатар.

ABSTRACT

The Mongolian language books, such as *Mongö nogöltea* (蒙語老乞大), *Ch'öbhae Mongö* (捷解蒙語) and *Mongö yuhae* (蒙語類解) published by Chuson's "Sayogwôn" at the end of XVIII century are inherited to our days are known in the Mongolian studies as "The three books for the study of Mongolian <in Korea>".

The information on issuing of 16 books written in Mongolian in Korea earlier the abovementioned three books is kept in the source called "*Chông gûg dae jôn*" (經國大典註解) The source has a note on bibliography and proper name comments, which was a subject for a number of researches in Korean and English (it can be reviewed in the bibliography of the article). Among the Mongolian researches, B.Sumyabaatar has mentioned about it. In this article the 16 books are introduced briefly.